

Б.Дэлгэрмаа

*МХСС-ийн Ардын урлаг судлалын  
тэнхимийн багш, докторант*

### Урлаг шинжлэх ухаан хоёрын нийтлэг ба ялгаатай талууд

Урлаг ба шинжлэх ухаан хоёрын нийтлэг ба ялгаатай талын асуудлыг авч үзэхдээ эхлээд урлаг гэж юу болох, шинжлэх ухаан гэж юуг хэлэх вэ? гэдэгт анхаарлаа хандуулах хэрэгтэй.

Урлаг бол бодит байдлыг уран сайхны дүрээр дамжуулан тусгаж илэрхийлдэг нийгмийн өвөрмөц үзэгдэл. Харин шинжлэх ухаан (грекийн *episteme*, латины *scientia*) гэдэг бол бодит байдлын тухай мэдлэгийн онолын схемчлэл ба боловсруулалт хийдэг хүний үйл ажиллагааны нэг хүрээ<sup>1</sup> юм. Өөрөөр хэлбэл, бодит байдлыг ойлголт, категори, хууль, зарчмуудын системээр илэрхийлдэг онол, арга зүйн бүхэл бүтэн системийг шинжлэх ухаан гэдэг. Шинжлэх ухаан нь юмс үзэгдлийн агуулга, мөн чанар, хууль зүй тогтлыг нээн илрүүлдэг.

Шинжлэх ухаан нь бодит байдлыг танин мэдсэн хүний үнэн мэдлэгийн цогц нийлбэр юм. Энэ бол бодит байдлыг бүхэлд нь ба тусгайд нь авч үзэх салбаруудад хамаатай үнэн бодомж, таамаглал, онолын асуудлуудын эмхэлж цэгцлэгдсэн бодит холбоо, зарчмууд юм. Шинжлэх ухаан нь туршлагын мэдлэгээс (эмпирик) ялгаатай зүйл нь зөвхөн “юу” гэдэг асуултанд хариулаад зогсохгүй, мөн юмс үзэгдлийн үндэс, шалтгааныг хайх “яагаад” гэдэг асуултанд хариулахыг эрмэлздэг явдал мөн.

Шинжлэх ухаан бол бодит байдлыг таньж мэдэх үндсэн хэрэгсэл. Шинжлэх ухааны бүх үйл ажиллагаа судлагдахууныхаа шинж чанарыг нээн гаргахад чиглэгддэг. Шинжлэх ухааныг дотор нь хоёр үндсэн төрөлд хуваана.

1. Байгалийн шинжлэх ухаан (хими, биологи, физик гэх мэт)
2. Нийгмийн шинжлэх ухаан (түүх, социологи, психологи, улс төр гэх мэт)

Судалж байгаа объектынхоо өвөрмөц онцлогоос хамаараад бодит байдлын маш олон төрөл байдлаас шалтгаалаад шинжлэх ухаан дотроо олон салбар чиглэлд хуваагддаг.

Одоо урлаг ба шинжлэх ухааны харилцааны тухай гол асуудал уруугаа оръё.

<sup>1</sup> Философский энциклопедический словарь. М., 1999. с 287.

**1. Урлагийн мэдлэг ба шинжлэх ухааны мэдлэг**

*/Шинжлэх ухааны уран бүтээл ба уран сайхны нээлт/*

Урлаг ба шинжлэх ухаан гэсэн соёлын салбарууд нь анхнаасаа шууд хуваагдчихсан биш, харин урт удаан түүхийн процесст аажмаар гарч ирсэн гэж үзэх нь зүйтэй юм.

“Шинжлэх ухааны уран бүтээл ба уран сайхны нээлт” гэж нэрлэдэгийн учир нь хэвшил болсон “уран сайхны бүтээл ба шинжлэх ухааны нээлт гэдэг томъёоллыг өөрчилж, шинжлэх ухааны концепцийг бүтээн байгуулах ба урлагийг бий болгодог судалгаа шинжилгээнд анхаарлыг хандуулах гэсэн юм” гэж Жак Мандельбройт хэлсэн байдаг. Тухайлбал, яруу найрагч Мишо яруу найрагт өөрийн дотоод ертөнцийг судалдаг ба энд өөрийгөө “үзэж таньдаг” гэсэн байхад уран барималч Жакометти уран барималд өөрийн сэрлийг судалдаг, уран зураач Дюбюфэ өөрийн зурсан зургаас өөрийгөө олж таньдаг, өөрийн хүсэл зоригийг мэддэг гэжээ. Зураач Саранцацрал: “Би сэтгэл дотроо бодож байгаагаа зураг дээр илэрхийлж гаргадаг. Зураг бол миний бодол санааны тэсрэлт юм” гэжээ.

Ер нь зураач бодит байдлыг эхлээд судална. Дараа нь оюун санааны боловсруулалтыг хийнэ. Оюун санаандаа боловсруулсан бүтэц байгууламжийн тусламжтайгаар хийсвэр урлагийг бүтээж бий болгоно. Уран зураг бий болох процессыг судалж үзвэл, юуны өмнө хүртэхүйгээс эхлээд ментал / оюун ухааны, сэтгэхүйн / дүрүүдийг дамжин бүрэн төгссөн бүтээл гарч ирнэ.

Урлагийн танин мэдэхүй нь хүртэхүй ба ментал дүрүүдийн илэрхийллээс эхэлнэ.

Хүртэхүй бол идэвхгүй зүйл биш юм. “Хүртэхүйн идэвхтэй байдлаас оюун ухаан эхэлдэг” гэж Пиаже<sup>1</sup> хэлсэн байдаг. Урлагт мэдрэмж хүртэхүй маш чухал үүрэгтэй байдгийг бид мэднэ. “Би бол нүдний боол билээ” гэж уран зураач Брам ван Вельдегийн хэлсэнчлэн зураач шиг /уран бүтээлч/ хүчтэй мэдрэмжтэй хүн хаана ч үгүй юм. Уран зурагт мэдрэмжийн онцгой өвөрмөц шинжүүд оршиж байдаг. Уран зургийн дүр нь зураачийн ментал дүрээс урган гарч ирдэг. Онцолж хэлбэл, энэ нь модернист зурагт бүр тод илэрнэ. Энэ талаар философич Ж. П. Сартр “сэтгэлийн орон зайд сэтгэл хөдлөлийн хөдөлгөөнүүд нь дүрийн хэлбэрээр оршдог” гэжээ. Ментал дүрийг илэрхийлэхэд зураас, шугам, хүрээ чухал ач холбогдолтой. Уран зурагт зураас нь юмсаас дутуугүйгээр бодит ба оюун санааны хөдөлгөөнийг бүтээдэг. Конус, цилиндр, дугуй, гурвалжин,

<sup>1</sup> Жан Пиаже /1896 онд төрсөн/ бол Швейцарийн психологич, генетик эпистемологийг үндэслэсэн хүн юм.

дөрвөлжин зэрэг геометрийн дүрсийн тусламжтайгаар уран зурагт бодит байдлыг бүтээдэг.

Ямар аргаар эрдэмтэд ба зураачид бодит байдлыг бүтээн туурвидаг вэ?

Шинжлэх ухаанд бодит байдлыг бүтээхдээ, туршлагын баримт нь онолын хүрээнд орж, онолыг баталдаг. Хэрэв онол нь баримттай ассимляцид орж байвал батлагдана. Хэрэв баримт онолд орохгүй байвал онол нь энэ шинэ баримтанд дасан зохицох хэрэгтэй болдог. Баримт анхааралд өртөхгүй байвал, онолын хүрээнд орж чадахгүй бөгөөд онолгүйгээр баримт нь түгэн дэлгэрч чадахгүй. Шинжлэх ухаан бол бодит байдлыг дахин боловсруулах хязгааргүй /төгсгөлгүй/ үргэлжлэх процесс ба шинжлэх ухааны онол нь математикийн шинжлэх ухаанд маш тодорхой илэрхийлэгддэг /харагддаг/.

Урлагаар танин мэдэхүйн нэг онцлог нь уран бүтээлд зайлшгүй хамаатай оригиналь (эх байдлыг) байдлыг шаарддаг.

Урлагийн бүтээлийн оригиналь шинж нь ертөнцийг давтагдашгүй, өвөрмөц байдлаар бодитойгоор тусгахад оршино. Уран сайхны арга шинжлэх ухааны аргаас эрс ялгаатай байдаг нь эндээс тодорхой харагддаг.

Шинжлэх ухааны танин мэдэхүй нь дээд зэргийн тодорхой нотолгоотой байх чанарт тулгуурладаг бөгөөд эрдэмтнээс өөрөөс нь хамаарах ямар нэгэн хувийн шинжийг харгалзаж үздэггүй. Шинжлэх ухааны бүх түүх аливаа субъективизмыг шинжлэх ухааны мэдлэгийн замаас ямагт зайлуулж байсан хийгээд объектив шинжийг л хадгалж ирснийг гэрчилнэ. Урлагийн бүтээл бол давтагдашгүй, өвөрмөц шинжтэй байдаг.

Шинжлэх ухааны нээлт бүтээлүүд нь түгээмэл шинжтэй байна. Тухайлбал, И.Ньютоны юм уу, эсвэл А.Эйнштейний нээлтийн үр дүнг судалж байгаа эрдэмтэнд, шинжлэх ухааны нээлт бүгдэд түгээмэл, хүртээлтэй байдаг учраас, түүний анхны уг сурвалжинд хандах шаардлагагүй юм. Шинжлэх ухаан бол хийсвэрлэлийн үр дүнд бий болж байгаа түүхэн хөгжлийн бүтээгдэхүүн байдаг.

Шинжлэх ухааны танин мэдэхүй дэх шинэ алхам бүр нь өмнөх үеийн сэтгэгчид, эрдэмтдийн ололт нээлтэнд тулгуурладаг бол урлаг, үүний эсрэгээр ихэвчлэн өөрийн бүх танин мэдэхүйн арга хэрэгслийг ашиглаж шинэ зүйлийг бүтээдэг. Урлаг нь уран бүтээлчийн субъектив ертөнцөөс хамаарч байдаг бөгөөд уг субъектив чанарыг үнэт чанар гэдэг үүднээс авч үздэг. Харин шинжлэх ухаан тодорхой байх чанарт тэмүүлдэг хийгээд объект, субъектын хоорондын заагийг эвдэхгүй байх зарчмыг баримталдаг бол урлаг үүнтэй тэр болгон тохирохгүй. Хэрэв Д.И.Менделеев химийн элементүүдийн үелэх системийн

таблицыг зохиогоогүй бол, өөр нэгэн эрдэмтэн үүнийг хийх л байсан. Гэтэл Ч.Лодойдамба “Тунгалаг Тамир”-ыг зохиогоогүй бол өөр ямар ч зохиолч эл бүтээлийг гайхамшигтайгаар туурвиж чадахгүй гэдэгт эргэлзэх зүйлгүй.

Урлаг ба шинжлэх ухаан нь ялгаатай хоёр зүйл боловч эдгээрт нийтлэг тал их бий. Үүнд:

1. Урлаг ба шинжлэх ухаан нь хүний ертөнцийг үзэх үзлийг төлөвшүүлнэ.
2. Урлаг, шинжлэх ухаан хоёр танин мэдүүлэх үүрэгтэй.
3. Эдгээр нь хоёулаа хүнийг хүмүүжүүлэх үүрэгтэй юм.
4. Урлаг, шинжлэх ухааны аль алинд нь интуитив танин мэдэхүй агуулагддаг.
5. Урлаг, шинжлэх ухаан нь нийгмийн (социальный) үүргийг гүйцэтгэдэг.
6. Эдгээр нь хүмүүст соёлыг төлөвшүүлэх үүрэгтэй. Шинжлэх ухаан нь хүмүүст сэтгэлгээний соёлыг төлөвшүүлдэг. Харин урлаг нь тухайн улсын үндэсний соёлын өв уламжлал ба дэлхий дахины соёлыг хүмүүст эзэмшүүлж байдаг.

Урлаг ба шинжлэх ухааны нийтлэг ба ялгаатай талын асуудлыг авч үзэхдээ, шинжлэх ухааныг философиор төлөөлүүлж, түүгээр жишээ авч асуудлыг тодруулахыг хичээе.

1. Урлаг ба философи дахь бодит байдал нь байгаль нийгмийн олон үзэгдэл үйл явцын универсаль нэгдмэл чанараар илэрнэ.
2. Урлаг, философийн аль алинд нь хүний тухай, ертөнцөд хүний эзлэх байр суурь, түүний ахуйн тухай асуудал гол байрыг эзэлдэг.
3. Урлаг ба философи нь бодит байдлыг үнэт чанарын талаас нь тусгадаг. Өөрөөр хэлбэл, хүн ба ертөнц, байгаль ба нийгэм, объектив ба субъектив талуудын харилцаа нь философи болон урлагт илүү ач холбогдолтой байдаг.
4. Философи ба урлаг нь хоёулаа танин мэдэхүйд тэмүүлдэг.
5. Философи, урлаг нь ертөнцийг үзэх үзлийн систем болдог.

Шинжлэх ухаан бол бодит байдлын юмс үзэгдлийн мөн чанар, хууль зүй тогтлыг судалдаг. Урлаг нь хүний оршихуй, хүн төрөлхтний хувь заяа, хүмүүсийн сэтгэл хөдлөл, амьдралын юмс үзэгдлийн субъектив утгыг авч үздэг. Одоо шинжлэх ухааныг бүтээгч эрдэмтэн ба урлагийн бүтээлийг туурвигч уран бүтээлч хоёрын нийтлэг ба ялгаатай талын асуудлыг авч үзье.

## **2. Уран бүтээлч ба эрдэмтэн**

Хэрэв урлагийн гол зорилго дискурсив аргын эсрэг байдаг интуицийн нэр хүндийг батлахад чиглэгддэг бол уран бүтээлч хүн өөрийн уг чанараараа эрдэмтний (энд тодорхой ба байгалийн шинжлэлийн ухааныг хамааруулан ярьж байна) оппонент юм гэж үзэж болно.

Эрдэмтэн бол шинжлэх ухааны хандлагыг тууштай хамгаалдаг бөгөөд энэ нь хатуу чанд дискурсив сэтгэлгээ, аксиом ба таамаглалуудын нарийн ангилал, үр дүнгийн дискурсив үндэслэгээ, шинжлэх ухааны судалгааны үндсийг практикаар шалгасан тодорхой ойлголт зэрэгт бүрэн дүүрэн үндэслэсэн байдаг. Энэ сэтгэлгээг эзэмшсэнээр бүтээлч үйл ажиллагааны онцгой хэв маяг төрж гарч ирнэ. Уг хатуу тогтчихсон сэтгэлгээ хүмүүнлэгийн ухааны салбарт болон урлагт төдийлөн таарч тохирдоггүй. Тэр ч байтугай зарим тохиолдолд байгалийн шинжлэлийн салбарт ч ийм байдал ажиглагддаг. Гэвч шинжлэх ухаан интуитив бодомжийн чадваргүйгээр бүрэн дүүрэн хөгжиж чадахгүй. Ийм учраас уран бүтээлч хүн чухамдаа дискурсийн эсрэг байдаг интуицийн нэр хүнд, үнэт чанарыг хамгаалан жинхэнэ бүтээлч шинжлэх ухааны төлөө тэмцэж байдаг.

Тодорхой шинжлэх ухааныг (математик, физик) бүтээгчид зарчмын асуудлуудаар нэгтгэн дүгнэсэн интуитив бодомжийг илэрхийлэхийг оролдох тохиолдол бүрдээ түүнээс зайлсхийж, урьд нь тогтчихсон хатуу дискурсив байдлаар аксиомуудаар шалгагдчихсан өмнөх хөрс суурин дээрээ тулгуурлах байдалд хүрч байлаа. Урьд нь туршлагын баримтуудаар илрээгүй (мэдэгдээгүй) шинэ зүйлийг илэрхийлсэн категоричлагдсан шаардлагууд л орон зай-цаг хугацааны төсөөлөл ба Ньютоны тэгшитгэлээс илүү ерөнхий онол буюу харьцангуй онолд шилжин орох нөхцлийг хангасан. Сонгодог механик нь гэрлийн задрах ба уусах атомуудын тогтворжилтын процессыг тайлбарлахад хангалтгүй болж, урт удаан хугацааны хүнд төвөгтэй оролдлогуудын дараа эцсийн эцэст квантын механикийн үндсийг томъёолох шийдвэртэй алхам хийхэд хүргэсэн.

Уран бүтээлч ба эрдэмтэн хоёрын ялгаа юунд оршиж байна вэ? Уран бүтээлч хүн өөртөө итгэлтэй, бардам чөлөөтэй байдаг, харин эрдэмтэд даруу байдаг гэдэгт үү? Мэдээж, гол шалтгаан бол үүнд биш, өөр илүү гүнзгий зүйлд байна гэдэг нь ойлгомжтой.

Сэтгэл зүйн талаар эрдэмтэн нь уран бүтээлчээс амар хялбар (хөнгөн) байдаг. Эрдэмтэн хүн шинэ зүйлийг бүтээчихээд, түүнийгээ бусад зүйлтэй харьцуулан үзэж, заавал туршлагаар, өөрөөр хэлбэл практикийн шалгуураар түүнийг шалгаж үздэг. Энэ бүхнийг өөрийн биеэр ба мөн хамтран

ажиллагсадтайгаа хийдэг. Энд үнэн, эсвэл худал (алдаа) нь эргэлзээ төрүүлэхгүйгээр (эргэлзээнд ямар ч зай үлдээлгүйгээр) гарч ирнэ. Эрдэмтэн хүн логик дүгнэлт нотолгоонд үндэслэдэг. Энэ нь эрдэмтэн судалгаа, шинжилгээний явцад хувийн шинж чанараа бүрэн гээж, өөрийн хүсэл сонирхлоос ангижирна гэсэн үг биш юм. Эрдэм шинжилгээ, судалгааны ажилд сэтгэл хөдлөл, интуиц /иррационал зүйлс/ багагүй үүрэг гүйцэтгэдэг байна. В. Г. Белинский: "Адилхан нэг зүйлийн тухай философич өгүүлэхдээ силлогизмоор, яруу найрагч дүр зургаар хэлэлцэнэ"<sup>1</sup> гэсэн нь эрдэмтэн хүн оюун дүгнэлтээр, уран бүтээлч хүн дүрээр сэтгэдэг гэдэг санааг хэлсэн байна.

Уран бүтээлч хүн бол үнэний шалгуурыг өөр арга замаар хийдэг. Товчоор хэлбэл, өөрийн хувийн дотоод үнэмшил ба бусад хүмүүсийн үнэмшлээр асуудалд ханддаг. Мөн уран бүтээлч асуудлыг интуитив замаар шийдвэрлэдэг. Уран бүтээлчийн ертөнцийг үзэх үзэл нь түүний оюун сэтгэлийн ертөнцийн байр суурь, уран бүтээлчийн харааг тодорхойлно.

Уран бүтээлчийн ухаан, сэтгэл, билэг авьяас, интуиц, хөдөлмөр, урлах эрдэм, чадвар, сэтгэлгээ цөм салшгүй нэгдэлд оршино. Энэ бүхний үр дүнд жинхэнэ урлаг бүтнэ. Уран бүтээлч хүн ихэвчлэн өөрөө сонголтыг хийж, шийдэж, өөрөө асуултанд хариулж байдаг.

Уран бүтээлч хүн ямар байх ёстойг Монголын судлаач, бурханч лам Г.Пүрэвбат "Бурханы шашин ба урлахуй ухаан" хэмээх судалгааны өгүүлэлдээ авч үзжээ. "Урлаачийн билэг чанар нь сүжиг төгс, урсгал номхон, асар атгаг үгүй, эрхтэн нугууд тодорхой, урлал дор төгс мэргэжсэн, номонд мэргэн, энэрэл ихтэй"<sup>1</sup> гэжээ. Харин урлаачийн тэвчвэл зохих чанар нь "Эрдэмд мэргэн үгүй, омог ихтэй, нөхөрлөхүйд амар үгүй, үг бачим ширүүн, хүндлэгдэх хүсэл ихтэй, шалтгаан төдийгөөр урлалаа сунжруулан орхих, амьтныг занах бөгөөд хар архийг эрхэмлэн буянаасаа хилэнц дор урвагч"<sup>2</sup> гэсэн нь уран бүтээлч хүн эрдэм номгүй, ууртай ширүүн, нөхөрсөг бус, алдар нэрд дуртай, урлагтаа үнэнч биш, залхуу хойрго, архи дарсанд дурлах зэрэг чанаруудаас хол байх ёстойг заажээ. Урлаачийн мэдвэл зохих онолын мэдэгдэхүүн нь: цэг, шугам, хавтгай, тэгш хэм, хэтрүүлэг буюу давууллын арга, айзам, нугалбар, харьцуулал, дөхөмчлөх, алслал, орон зайн ухагдахуун, ерөнхийлөл, бэлгэдэх зэрэг урлаач хүмүүний мэдвэл зохих уламжлалт онолын асуудал болон алив хүмүүн, бодисын хураасан үйл, дотоод бүтэц тогтолцооноос шалтгаалан гадаад дүр

<sup>1</sup> В.Г.Белинский. Полн.собр.,соч.Т.1.М., 1966, с. 311.

<sup>1</sup> Г.Пүрэвбат. Бурханы шашин ба урлахуй ухаан. Монгол иргэншлийн үлэмж өв. УБ.,2001. 119-р тал.

<sup>2</sup> Мөн тэнд

хэлбэрээ олох жам зэрэг юм. “Гадаад хэлбэр дүрээр нь дотоод мөн чанарыг нь илтгэн харуулах их шинжлэл лугаа уялдан барилдсан урлаачийн зөн билэг, зөв шинжлэлийн ухаан багтана”<sup>1</sup> гэсэн нь урлаач хүн юмс үзэгдлийн гадаад хэлбэрийг дотоод мөн чанартай нь уялдуулан гаргахдаа өөрийн интуицэд тулгуурладаг болох тухай санаа юм.

Сэргэн мандалтын үеийн нэрт зураач Леонардо да Винчи *шинжлэх ухаан ба урлагийг байгалийг судлах ижил төвшингийн хоёр арга* гэж үзсэн. Тэр хэлэхдээ: “Уран зураг бол шинжлэх ухаан бөгөөд байгалийн хууль ёсны охин нь юм” гэжээ. Энэ үед урлагийг хамгийн бүтээлч шинжтэй зүйл гэж өндөр үнэлж байв. Сэргэн мандалтын үеийн зураачийг бүтээлч шинж чанараар нь Бурхан-уран бүтээлч гэж үзэж байв. Өөрөөр хэлбэл, уран зураачийг бурхантай адилтгаж байв. Тэрээр *сэтгэлгээ ба уран зураг бол бодит байдлыг таньж мэдэх хоёр арга юм гэж үзсэн.*

Шинжлэх ухаан, урлаг хоёр харилцан нөхцөлдөж байдаг. Эрдэмтэн хүний бүтээлд гоо зүйн хүчин зүйл хөшүүрэг болох нь олонтаа байдаг. Дэлхийн алдартай олон эрдэмтэд өөрсдийн эрдэм шинжилгээ, судалгааны гол ажилдаа анхаарлаа хандуулдаг байсан төдийгүй, урлагт гүнзгий татагдаж, шүлэг, роман, яруу найраг бичиж, зураг зурж, хөгжим тоглодог байжээ. Тухайлбал, А.Эйнштейн хийл хөгжим тоглодог, Ч.Дарвин Шекспирийн зохиол бүтээлийг ихээхэн сонирхон уншдаг байсан. Эрдэмтэн Н.Бор яруу найрагч зохиолч Гёте, Шекспир, Кьеркегор нарыг шүтдэг байжээ. Квантын механикийг үндэслэгч Макс Планк төгөлдөр хуурыг авьяаслаг хөгжимддөг байв. Академич А. Ф. Иоффе “Планк гуайнд очих болгондоо түүний төгөлдөр хуурын гайхамшигт тоглолтыг сонсдог сон. Тэр сонгодог хөгжим И. Бах, Л. Бетховен, И. Брамсын бүтээлийг хөгжимдөнө”<sup>1</sup> гэжээ.

Мөн аугаа их философич И.Кант, Г.Гегель нар байгалийн шинжлэл, нийгмийн ухааны салбарын аль алианаар нь ажиллаж, зохиол бүтээлээ туурвиж байсан.

Шинжлэх ухаан, уран бүтээл хоёр хүний оюуны амьдрал, үйл ажиллагааны хоёр салбар, үндсэн хоёр хэлбэр мөний хувьд нийтлэг, түгээмэл, өвөрмөц онцлог зүйлүүд бий. Оюуны үнэт бүтээл, эрдэм шинжилгээний туурвил, уран сайхны бүтээлийг бий болгоход аль алинд нь билгүүн эрдэм, авьяас, уран чадвар, интуиц, уран сэтгэмж чухал үндэс болдог билээ. Иймээс

<sup>1</sup> Мөн тэнд. 120-р тал

<sup>1</sup> А.Ф. Иоффе. Встречи с физиками. М., 1960. с. 78-79

уран бүтээлч шинжлэх эрдэмтэн байж, шинжээч хүн уран бүтээлч байж зорилгодоо хүрдэг.

Урлаг бол ертөнц, нийгэм, бодит амьдралын үнэний уран сайхны нээлт учир урлагийн танин мэдэхүй онол нь /урлагийн эпистемологи нь/ урлагийн философийн үндэс болно. Өөрөөр хэлбэл, амьдрал, ертөнцийг ойлгож танин мэдэж, түүнээ тунгаан боловсруулах явдал нь танин мэдэхүйн процессоос өөр юу ч биш билээ.

Орчин үед урлаг нь шинжлэх ухаан техникийн үйл ажиллагаанд гарцаагүй хэрэгтэй бүтээлч сэтгэлгээ, чадварын /уран зөгнөл, эвристик сэтгэлгээ г. м./ хөгжилд чухал ач холбогдолтой байна.

Урлаг шинжлэх ухаан хоёр бол туйлын эсрэг тэсрэг зүйлүүд биш бөгөөд ертөнцийг танин мэдэх процесст бие биенийгээ нөхөн гүйцээж байдаг гэдгийг энд дахин онцлон тэмдэглэе.

**Ашигласан ном:**

1. Бергер Л.Г. "Эпистемология искусства" М.,1997
2. Гильберт К.Э. , Кун.Г. "История эстетики" СПб.,2000
3. Кривцун О.А. "Эстетика" М.,1998
4. Фейнберг Е.Л.Кибернетика, логика, искусство" М.,1981
5. Colin Lyas. Aesthetics. London.,1997